

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
БҮХИЙ ХОРШООДЫН 2008 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2009.02.20

Улаанбаатар хот


НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант жилд Хорооны тогтоолоор 45 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, 17 ХЗХ-дын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 209 ХЗХ-ны жилийн эцсийн санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдсан.

Эдгээрээс 11 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 5.3 хувь нь санхүүгийн тайлангаа ирүүлээгүй тул өмнөх улирлаар нь нэгтгэлд хамруулж, 198 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 94.7 хувь нь зохих журмын дагуу санхүүгийн болон зохистой харьцааны тайланг ирүүлснээр нийт 209 ХЗХ буюу ХЗХ-дын 100.0 хувь нь санхүүгийн нэгтгэлд хамрагдлаа.



2007 оны жилийн эцсийн байдлаар нийт гишүүдийн тоо 21,667 байсан бол тайлант жилд ХЗХ-дын нийт гишүүдийн тоо 24,655 болж өссөн байна.



Судалгаанаас үзэхэд ХЗХ-дын олгож буй зээлийн арифметик дундаж хүүгийн түвшин 3.6, жигнэсэн дундаж хүү 3.2 хувь, хадгаламжийн хүүгийн арифметик дундаж хүү 1.8, жигнэсэн дундаж хүү 1.5 хувь тус тус байна.


ХОЁР. ОРОН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БҮЙ ХОРШООДЫН ТАЛААР

Орон нутагт 108 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ХЗХ-дын 51.7 хувийг, тэдгээрийн нийт актив 6,457.246.1 мянган төгрөг нь нийт активын 15.5 хувийг, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 5,161,853.7 мянган төгрөг нь нийт олгосон зээлийн 15.9 хувийг, нийт


татан төвлөрүүлсэн хадгаламж 3,491,563.6 мянган төгрөг нь нийт хадгаламжийн 12.6 хувийг, нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 1,651,431.9 мянган төгрөг нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 21.5 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-д 12,076 гишүүнтэй байгаа нь нийт хоршоодын гишүүдийн 48.9 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-г байршлын хувьд авч үзвэл дараах байдалтай байна.



Тайлант онд тусгай зөвшөөрөл авсан ХЗХ-дын 66.6 хувь нь орон нутаг буюу алслагдсан сум, багт үйл ажиллагаа эрхлэж байгаа нь санхүүгийн үйлчилгээг иргэдэд хүргэх, жижиг, дунд үйлдвэрлэл болон орлого багатай иргэдийг санхүүгийн үйлчилгээнд хамруулах талаар тодорхой үр дүнд хүрсэн байна.



ГУРАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Тайлант жилд нийт орлого өмнөх оноос 2,180,183.3 мянган төгрөгөөр буюу 20.7 хувиар өсч 12,699,436.6 мянган төгрөгт хүрсэн ба нийт орлогын бүтцийн өөрчлөлт дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		2007.IV УЛИРАЛ	ХУВЬ	2008.IV УЛИРАЛ	ХУВЬ	ӨӨРЧЛӨЛТ
I	ХҮҮГИЙН ОРЛОГО	8,312,131.57	79.1%	11,092,623.44	87.3%	2,780,491.87
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	6,742,712.66	64.1%	9,908,986.72	78.0%	3,166,274.06
	Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	187,398.01	1.8%	136,179.22	1.1%	(51,218.79)
	Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	1,364,843.28	13.0%	1,018,119.68	8.0%	(346,723.60)
	Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	17,177.62	0.2%	756.79	0.0%	(16,420.83)
	Бусад хүүгийн орлого	-		28,581.03	0.2%	28,581.03
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	1,644,860.98	15.7%	444,415.85	3.5%	(1,200,445.13)
	Элсэлтийн хураамж	9,557.12	0.1%	16,402.77	0.1%	6,845.65
	Гишүүний татвар	11,644.35	0.1%	18,540.41	0.1%	6,896.06
	Үйлчилгээний хураамж	57,966.19	0.6%	89,911.75	0.7%	31,945.56
	Үйл ажиллагааны бусад орлого	1,565,693.32	14.9%	319,560.91	2.5%	(1,246,132.41)
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	552,046.32	5.4%	1,153,582.13	9.1%	601,535.81
	Торгуулийн орлого	5,690.19	0.1%	1,420.00	0.0%	(4,270.19)
	Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	41,976.88	0.4%	13,490.73	0.1%	(28,486.15)
	ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	2,414.70	0.1%	158,455.26	1.2%	156,040.56
	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	118,842.86	1.1%	677,091.18	5.3%	558,248.32
	Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	966.87	0.0%	3,409.53	0.0%	2,442.66
	Бусад орлого	373,590.39	3.6%	139,946.17	1.1%	(233,644.22)
	Онцгой шинжтэй орлого	8,564.43	0.1%	159,769.26	1.3%	151,204.83
IV	ЕРДИЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР ОРЛОГО	10,214.39	0.1%	6,593.18	0.1%	(3,621.21)
	Ердийн бус орлого	10,214.39	0.1%	8,815.15	0.1%	(1,399.24)
V	НИЙТ ОРЛОГО:	10,519,253.26	100.0%	12,699,436.57	100.0%	2,180,183.31

Нийт орлогын 78.0 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байгаа нь зээлийн үйл ажиллагааны орлого нь нийт орлогын гол эх үүсвэр болж байгааг илтгэж байна.

Нийт зардал өмнөх оноос 2,604,849.1 мянган төгрөгөөр буюу 31.8 хувиар өсч 10,804,548.7 мянган төгрөгт хүрсэн ба нийт зардлын бүтцийн өөрчлөлт дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		2007.IV УЛИРАЛ	ХУВЬ	2008.IV УЛИРАЛ	ХУВЬ	ӨӨРЧЛӨЛТ
I	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	5,655,493.87	69.0%	6,516,367.82	60.3%	860,873.95
	Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	2,273,626.41	27.7%	2,644,748.44	24.5%	371,122.03
	Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх хугацаатай)	2,808,552.44	34.3%	3,289,501.87	30.4%	480,949.43
	Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жилийн хугацаатай)	447,342.77	5.5%	141,187.57	1.3%	(306,155.20)
	Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	119,212.63	1.5%	432,575.98	4.0%	313,363.35
	Бусад хүүгийн зардал	6,759.62	0.1%	8,353.96	0.1%	1,594.34
II	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	221,838.34	2.7%	1,026,666.08	9.5%	804,827.74
	Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	194,011.24	2.3%	1,011,633.96	9.4%	817,622.72
	Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	3,899.53	0.1%	12,982.40	0.1%	9,082.87
	Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	23,927.57	0.3%	850.00	0.0%	(23,077.57)
	Бусад эрсдэлийн зардал	-		1,199.72	0.0%	1,199.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,864,937.16	22.7%	2,362,736.83	21.9%	497,799.67
	Боловсон хүчний зардал	816,525.28	10.0%	1,262,499.69	11.7%	445,974.41
	Бусад төрлийн зардал	1,048,411.88	12.8%	1,100,237.13	10.2%	51,825.25
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	197,287.81	2.4%	655,388.40	6.1%	458,100.59
	Торгуулийн зардал	3,904.38	0.0%	7,159.88	0.1%	3,255.50

	Ногдол ашгийн зардал	6,088.91	0.1%	22,805.34	0.2%	16,716.43
	Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	16,995.39	0.2%	1,844.87	0.0%	(15,150.52)
	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	94,533.53	0.0%	589,764.06	5.5%	495,230.53
	Үйл ажиллагааны бус бусад зардал	75,765.60	1.1%	33,814.25	0.3%	(41,951.35)
V	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	3,779.84	0.9%	2,221.97	0.0%	(1,557.87)
VI	ТАТВАРЫН ЗАРДАЛ	256,362.56	3.1%	241,167.66	2.2%	(15,194.90)
VII	НИЙТ ЗАРДАЛ	8,199,699.58	100.0%	10,804,548.76	100.0%	2,604,849.18

Нийт зардлын 60.3 хувь нь хүүгийн зардал, 21.9 хувь нь үйл ажиллагааны зардал буюу боловсон хүчний холбогдолтой зардал байна.

		/мянган төгрөгөөр/		
	ҮЗҮҮЛЭЛТ	2007-IV УЛИРАЛ	2008-IV УЛИРАЛ	ӨӨРЧЛӨЛТ
I	НИЙТ ОРЛОГО	10,519,253.26	12,699,436.57	2,180,183.31
II	НИЙТ ЗАРДАЛ	8,199,699.58	10,804,548.76	2,604,849.18
	ТАТВАРЫН ДАРААХЬ ЦЭВЭР АШИГ	2,319,553.71	1,894,887.43	(424,666.28)

Тайлант хугацаанд 161 ХЗХ буюу нийт ХЗХ-ны 77.3 нь хувь ашигтай ажилласан ба тэдгээрийн нийт ашиг 2,335,042.4 мянган төгрөг байна. Ашигтай ажилласан ХЗХ-дын арифметик дундаж ашиг 14,503.4 мянган төгрөг байна.

Алдагдалтай ажилласан зарим шалтгааныг нь тодруулж авч үзвэл, үйл ажиллагааны зардал өндөр, зээлийн чанар муудсанаар зээлийн болзошгүй эрсдэлийн зардал өмнөх оны мөн үеэс 4.6 дахин өсч 1,026,066.1 мянган төгрөгт хүрсэнтэй холбоотой байна.

Ашгийн түвшин 424,666.3 мянган төгрөг буюу 18.3 хувиар буурсан нь зардлын өсөлтийн хурдац нь орлогын өсөлтийн хурдацаас их байгаагаас шалтгаалжээ.

ДӨРӨВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Активын талаар

Тайлант онд нийт активын бүтэц дараах байдалтай байна. Үүнд

		/мянган төгрөгөөр/			
ХӨРӨНГӨ	2007.IV УЛИРАЛ	Нийт активт эзлэх хувь	2008.IV УЛИРАЛ	Нийт активт эзлэх хувь	ӨӨРЧЛӨЛТ
I. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	34,082,240.23	95.7%	40,361,741.24	96.8%	6,279,501.01
I МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,600,161.35	38.2%	7,109,734.04	17.0%	(6,490,427.31)
1. Касс дахь бэлэн мөнгө	1,250,534.00	3.5%	1,751,594.31	4.2%	501,060.31
2. Банкинд байршуулсан харилцах	2,716,882.52	7.6%	2,579,868.47	6.2%	(137,014.04)
3. Банкинд байршуулсан хадгаламж	9,087,421.01	25.5%	2,745,387.45	6.6%	(6,342,033.56)
4. Бусад байгууллагад байршуулсан харилцах	-	0.0%	32,522.60	0.1%	32,522.60
5. Бусад байгууллагад байршуулсан хадгаламж	545,323.82	1.5%	361.20	0.0%	(544,962.62)
II ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	18,037,539.10	50.6%	30,653,312.20	73.5%	12,615,773.10
6. Нийт зээл	19,290,694.65	54.1%	32,377,976.33	77.6%	13,087,281.69
6.1. Хэвийн зээл	17,232,856.77	48.4%	29,006,400.82	69.6%	11,773,544.05
6.2. Хугацаа хэтэрсэн зээл	609,133.12	1.7%	1,179,553.88	2.8%	570,420.76
6.3. Чанаргүй зээл	1,448,704.76	4.1%	2,192,021.64	5.3%	743,316.88
Хэвийн бус	290,666.50	0.8%	495,375.58	1.2%	204,709.09
Эргэлзээтэй зээл	343,845.86	1.0%	496,280.28	1.2%	152,434.42
Муу зээл	814,192.40	2.3%	1,200,365.77	2.9%	386,173.37
6.4 (Зээлийн эрсдэлийн сан)	(1,253,155.55)	-3.5%	(1,724,664.13)	-4.1%	(471,508.58)
III АВЛАГА (ЦЭВРЭЭР)	1,959,909.85	5.5%	2,076,724.20	5.0%	116,814.35
7. Байгууллага, хүмүүсээс авах авлага	319,540.84	0.9%	383,613.28	0.9%	64,072.44
7.1 (Байгууллага, хүмүүсээс авах авлага эрсдэлийн сан)	(71,201.71)	-0.2%	(43,823.97)	-0.1%	27,377.74
8. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,711,570.71	4.8%	1,736,934.89	4.2%	25,364.17
IV БУСАД ХӨРӨНГӨ	237,462.53	0.7%	160,954.75	0.4%	(76,507.78)
9. Материал үнэ бүхий зүйл	185,543.66	0.5%	102,163.01	0.2%	(83,380.65)
10. Урьдчилж төлсөн зардал, тооцоо	29,204.26	0.1%	17,292.68	0.0%	(11,911.58)
11. Бусад актив	22,714.62	0.1%	41,499.06	0.1%	18,784.45
V ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ	247,167.39	0.7%	361,016.05	0.9%	113,848.65

(ЦЭВРЭЭР)					
12. Өмчлөх бусад хөрөнгө	269,567.39	0.8%	401,739.86	1.0%	132,172.46
13. (Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан)	(22,400.00)	-0.1%	(40,723.81)	-0.1%	(18,323.81)
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,545,366.05	4.3%	1,338,597.63	3.2%	(206,768.42)
VI ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,318,518.16	3.7%	1,199,542.65	2.9%	(118,975.50)
14. Үндсэн хөрөнгө	1,741,043.62	4.9%	1,668,093.01	4.0%	(72,950.61)
15. (Үндсэн хөрөнгийн элэгдэл)	(422,525.47)	-1.2%	(468,550.35)	-1.1%	(46,024.89)
VII БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	226,847.89	0.6%	139,054.97	0.3%	(87,792.92)
16. Биет бус хөрөнгө	20,700.22	0.1%	23,743.87	0.1%	3,043.65
17. Бусад	206,147.68	0.6%	115,311.11	0.3%	(90,836.57)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	35,627,606.28	100.0%	41,700,338.87	100.0%	6,072,732.59

Эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт актив өмнөх оноос 6,072,732.6 мянган төгрөг буюу 17.0 хувиар өссөн.

Хүүгийн орлого авчирдаг активуудын дүн 35,123,724.9 мянган төгрөг болж нийт активт эзлэх хувийн жин нь 84.2 хувь хүрчээ.

4.2 Активын багцын чанар

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдлийн бүтэц дараах байдалтай байна.

АКТИВ	/мянган төгрөгөөр/				
	2007.IV УЛИРАЛ	ХУВЬ	2008.IV УЛИРАЛ	ХУВЬ	ӨӨРЧЛӨЛТ
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	18,037,539.10		30,653,312.20		12,615,773.10
Нийт зээл	19,290,694.65	100.0%	32,377,976.33	100.0%	13,087,281.69
1. Хэвийн зээл	17,232,856.77	89.3%	29,006,400.82	89.6%	11,773,544.05
2. Хугацаа хэтэрсэн зээл	609,133.12	3.2%	1,179,553.88	3.6%	570,420.76
3. Чанаргүй зээл	1,448,704.76	7.5%	2,192,021.64	6.8%	743,316.88
Хэвийн бус	290,666.50	1.5%	495,375.58	1.5%	204,709.09
Эргэлзээтэй зээл	343,845.86	1.8%	496,280.28	1.5%	152,434.42
Муу зээл	814,192.40	4.2%	1,200,365.77	3.7%	386,173.37
4(Зээлийн эрсдэлийн сан)	(1,253,155.55)		(1,724,664.13)		(471,508.58)

Чанаргүй зээлийн үзүүлэлтүүдийг өмнөх онтой харьцуулахад 743,316.9 мянган төгрөг буюу 51.2 хувиар өссөн ч нийт зээлийн багцад эзлэх хувь нь 7.5-6.8 болж буурсан. Энэ нь зээлийн багцын өсөлт чанаргүй зээлийн өсөлтөөс их байгаатай холбоотой.

Хоршооны удирдлагын чадвар ядмаг, санхүүгийн менежментийн түвшин муу, дотоод хяналтын үр өгөөж тааруу, ажилтнуудын ажил хэрэгч ур чадвар хангалтгүй зэрэг үзүүлэлтүүдээс зээлийн чанар муудаж, болзошгүй эрсдэлийн зардал өмнөх оноос 4.6 дахин өсчээ.

ТАВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЦИЙН ТАЛААР

5.1 Нийт эх үүсвэрийн талаар

Тайлант онд нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтэц дараах байдалтай байна.

ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2007.IV УЛИРАЛ	ХУВЬ	2008.IV УЛИРАЛ	ХУВЬ	ӨӨРЧЛӨЛТ
1. ӨР ТӨЛБӨР	28,269,308.40	79.3%	30,827,985.13	73.9%	2,558,676.73
ХАДГАЛАМЖ	25,959,653.55	72.9%	27,671,713.73	66.4%	1,712,060.18
1. Хугацаагүй	2,757,959.91	7.7%	2,130,203.71	5.1%	(627,756.20)
2. Хугацаатай	23,201,693.63	65.1%	25,541,510.02	61.3%	2,339,816.38
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	386,851.61	1.1%	753,832.26	1.8%	366,980.65
3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	386,851.61	1.1%	752,132.26	1.8%	365,280.65
4. Богино хугацаат төслийн санхүүжилт	-	0.0%	1,700.00	0.0%	1,700.00
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,807,031.28	5.1%	1,928,932.54	4.6%	121,901.26

5. Татварын төлөх өглөг	22,412.90	0.1%	43,078.99	0.1%	20,666.10
6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,526,669.33	4.3%	1,661,785.80	4.0%	135,116.47
7. Өглөг	193,944.78	0.5%	159,993.66	0.4%	(33,951.12)
8. Бусад пассив	64,004.26	0.2%	64,074.08	0.2%	69.82
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	115,771.97	0.3%	473,506.61	1.1%	357,734.64
9. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	115,771.97	0.3%	473,506.61	1.1%	357,734.64
10. Урт хугацаат төслийн санхүүжилт	-	0.0%	-	0.0%	-
2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	7,358,297.88	20.7%	10,872,353.74	26.1%	3,514,055.85
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	6,513,649.79	18.3%	7,668,248.39	18.4%	1,154,598.60
11. Хувь нийлүүлсэн хөрөнгө	6,513,649.79	18.3%	7,668,248.39	18.4%	1,154,598.60
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	844,648.09	2.4%	3,204,105.35	7.7%	2,359,457.25
12. Нөөцийн сан	552,702.61	1.6%	783,413.60	1.9%	230,711.00
13. Дахин үнэлгээний сан	19,510.87	0.1%	61,954.70	0.1%	42,443.83
14. Нийгмийн хөгжлийн сан	96,441.36	0.3%	92,603.24	0.2%	(3,838.12)
15. Бусад сангууд	88,405.49	0.2%	94,087.45	0.2%	5,681.96
16. Хандив, тусламж	24,296.83	0.1%	25,407.04	0.1%	1,110.21
17. Бусад өмч	323.32	0.0%	2,633.06	0.0%	2,309.74
18. Тайлангийн үеийн ашиг/алдагдал	1,916,833.97	5.4%	1,894,887.43	4.5%	(21,946.54)
19. Хуримтлагдсан ашиг/алдагдал	(1,853,866.36)	-5.2%	249,118.82	0.6%	2,102,985.18
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	35,627,606.29	100.0%	41,700,338.87	100.0%	6,072,732.58

Өөрийн хөрөнгө 3,514,055.9 мянган төгрөг буюу 47.8 хувиар, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 1,712,060.2 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар тус тус өссөнтэй холбоотойгоор нийт эх үүсвэр өмнөх оноос 6,072,732.6 мянган төгрөг буюу 17.1 хувиар өсчээ.

Богино хугацаат зээл, урт хугацаат өр төлбөрийн дүн нийт эх үүсвэрт 2.9 хувийг эзэлж байгаа нь зөвхөн бусдаас зээл авсан 43 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 20.6 хувьд нь хамааралтай байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР